



МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2020.11.30 № 05/13167

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан  
мэдүүлгийг хянасан тухай


Дулааны Хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн хангамж үйлчилгээ хариуцсан дэд захирлаар томилогдохоор нэр дэвшсэн Чүлтэмийн Доржийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй, нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан бусад хориглолт хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

Түүнчлэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасны дагуу 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргахыг анхаарна уу.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг гаргах, хянах үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлсэн тул цаашид мэдүүлгийг тус газарт цахимаар ирүүлж байхыг үүгээр мэдэгдье.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,  
ЭРХЭЛСЭН КОМИССАР *Хашбаатар* Х.ХАШБААТАР



*З.Нямсүрэнг*  
Холбогдох  
Материалыг бүрдүүлж  
тушаал гаргах  
*Нямсүрэнг* ХН/с.

*ЗУХ.*  
*ХН/с*  
0019617